



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 11/191

Номгон

Эзэмшил газрын зөрчлийг арилгах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 113 дугаар тогтоолын 1.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч Ж.Бат-Эрдэнийн хүсэлтийг харгалзан аймгийн Засаг даргын 2010 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 278 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсэгт заасан иргэн Ж.Бат-Эрдэнэд холбогдох газрын талбайн хэмжээ хэсгийг хавсралтад тусгаснаар өөрчилсүгэй.

2.Илүү эзэмшиж буй 163 м2 газрын үнийг төлүүлэн, нэмж эзэмшүүлж зөрчлийг арилгасугай.

3.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Ж.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210477

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
18-ны өдрийн А/191 дүгээр захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Ж.Бат-Эрдэнэ	ВЭ70040518	0407002323-001	Орон сууц	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын гудамж-3, 3306 тоот	68 м2	163 м2	231 м2

_____оОо_____